



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/299

Булган сум

**Бэлчээр хамгаалах  
арга хэмжээг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/96 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх арга хэмжээг Улсын төсвийн хөрөнгөөр Рашаант, Дашинчилэн, Сайхан сумдын бэлчээрийн 20.0 мянган га талбайд энэ оны 05 дугаар сарын 01-нээс 5 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах талбайн хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөдөлмөр аюулгүй ажиллагааг сайтар хангаж, ажиллах хүн, хүч, техник хэрэгсэл дайчлах, ажилгүй иргэд болон малчдыг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй гүйцэтгэхийг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Мэргэжил арга зүй зөвлөмжөөр хангаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

04 дүгээр сарын 20-ний өдрийн А/2024 дугаар захирамжийн хавсралт



БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ МЭРЭГЧИДТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

д/д	Сумын нэр	Талбайн хэмжээ /мян.га/	Бэлдмэлийн хэмжээ /тн/	Тэмцэх арга
1	2	3	4	5
1	Рашаант	13.3	20.0	Микробиологийн арга (Бактерийн бэлдмэл)
2	Дашинчилэн	3.0	4.5	
3	Сайхан	3.7	5.5	
	<b>Бүгд</b>	<b>20.0</b>	<b>30.0</b>	